

Батлав. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга

_____ /

/

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

Нью Спейс ХХК-ийн захирал

_____ /Ж.САРУУЛ/

**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НУТАГТ БАЙРЛАХ
НЬУ СПЕЙС ХХК-ИЙН НООС, НООЛУУР УГААХ ҮЙЛДВЭРИЙН
ТӨСЛИЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/Нью Спейс ХХК Регистр: 5062411/

Хянасан:

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын мэргэжилтэн

_____ /

/

Боловсруулсан:

Нью Спейс ХХК байгаль орчны зөвлөх

_____ Б.Батбаяр

Нью Спейс ХХК ХАБЭАБО-ны ажилтан

_____ У.Энхзолбоо

Төлөвлөгөөний агуулга

1	Баянгол дүүргийн нутагт байрлах ноос, ноолуур угаах үйлдвэрийн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө.....	1
1.1	Төслийн товч танилцуулга.....	1
1.2	Ноос, ноолуур угаах үйлдвэрийн танилцуулга.....	1
1.3	Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт.....	2
1.3.1	Нийгэм-эдийн засгийн өнөөгийн байдал.....	6
1.4	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	8
1.4.1	Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	8
1.4.2	Уур амьсгалд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	8
1.4.3	Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	8
1.4.4	Гадаргын усанд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	8
1.4.5	Газрын доорх усанд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	9
1.4.6	Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	9
1.4.7	Ургамлан нөмрөгт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	9
1.4.8	Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	9
1.4.9	Дуу шуугианаас нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	10
1.4.10	Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	10
1.4.11	Түүх, соёлын өвд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	10
1.4.12	Нийгэм эдийн засагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	10
1.5	Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт.....	10
1.6	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	11
1.7	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	19
1.8	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	19
1.9	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	20
1.10	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	24
1.11	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ).....	26
1.12	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	29
1.13	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	30

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1-1	Ноос, ноолуур угаах үйлдвэрийн төслийн 2022 оны БОМТ-ний нийт зардлын хураангуй.....	10
Хүснэгт 1-2	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	12
Хүснэгт 1-3	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	19
Хүснэгт 1-4	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	20
Хүснэгт 1-5	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	20
Хүснэгт 1-6	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	24
Хүснэгт 1-7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	27
Хүснэгт 1-8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	29
Хүснэгт 1-9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	31

1 Баянгол дүүргийн нутагт байрлах ноос, ноолуур угаах үйлдвэрийн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1.1 Төслийн товч танилцуулга

Төслийн нэр

Ноос, ноолуур угаах үйлдвэр

Төсөл хэрэгжүүлэгч

Улсын бүртгэлийн дугаар: 9019073113

Регистрийн дугаар: 5062411

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг/байршил, холбогдох утас

Улаанбаатар, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Үйлдвэрийн тойруу, 34/1, Утас: 99229437

1.2 Ноос, ноолуур угаах үйлдвэрийн танилцуулга

Нью спэйс ХХК нь 2006 онд байгуулагдан ба 2007 онд Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт жилдээ 3,000 тонн ноос, ноолуур угаах хүчин чадал бүхий үйлдвэр, контор, үйлчилгээ, угаасан түүхий эд болон түүхий эдийн агуулах зэрэг нийт 10,488 м² талбай бүхий барилга, байгууламжууд, мөн 300 м³ багтаамж бүхий цэвэрлэх тунгаагуур, 630 кВт-ийн трансформаторын хамтаар барьж ашиглалтанд оруулж, өнөөг хүртэл тасралтгүй ажиллаж байна.

Ноос, ноолуур угаах үйлдвэр нь 108 м x 18 м буюу 1,944 м² талбайтай, ноос бутлах машин 1 ширхэг, пресслэгч DY160 маркийн 2 ширхэг машин, LB-023-152 маркийн ноос, ноолуур угаах зориулалттай угсраа дамжлагат 4, 5 дугаарын онгоцны бага бохирдолтой усыг 1, 2 дугаар усан онгоцонд эргүүлэн татаж ашиглах дэвшилтэт 2 ширхэг машинтай. Үйлдвэрийн талбай нь ноос угаах машины харалдаа цувраа 13 ширхэг буюу 4 эгнээ, пресслэх машины талбайд 4 ширхэг буюу нийт 56 ширхэг гэрэлтүүлэгтэй, 80 см-ийн диаметртэй 5 ширхэг агааржуулах сэнстэй. Ноос, ноолуур угаах машины хоосон буюу ачаалалтай үеийн 1 цикл нь 30 минутын хугацаатай. Монгол улсын Засгийн газрын 2018.03.14-ний өдрийн 73 дугаар тогтоолын дагуу 2019 онд БНХАУ-д үйлдвэрлэсэн цагт 5 тонн бохир ус шүүж, цэвэрлэх DAF-5 маркийн автомат төхөөрөмж суурилуулж, ашиглалтанд оруулсан. Үйлдвэрийн түүхий эд бэлтгэл болон бараа бүтээгдэхүүний борлуулалт, эрэлт, нийлүүлэлтээс шалтгаалан жил бүрийн 1, 2 дугаар сар болон 3 сарын эхээр үйлдвэрлэлийг зогсоон техник үйлчилгээ, засварын ажил хийдэг. Цаашид энэ дэвшилтэт технологи дээр суурилан үйлдвэрлэлээ өргөтгөн угаасан ноос, ноолуураа ээрсэн утас болгох цаашлаад бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилт тавин ажиллаж байна.



Фото 1-1 Ноос угаах үйлдвэрийн гаднах байдал

1.3 Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

Газрын гадарга, хэвлий

Нью Спейс компанийн үйл ажиллагаа явуулж буй барилга нь Туул голын хөндийд байрлана. Туул голын хөндий нь зүүнээс баруун тийш 30 орчим км сунаж тогтсон, өргөн нь 4-5 км, далайн түвшнээс дээш 1250-1300 м өндөрт өргөгдсөн бөгөөд урд талаараа Богдхан уул (2258 м), хойд талаараа Баянзүрх уул (1843.3 м), Чингэлтэй түүний салбар уулсаар хүрээлэгдэнэ.

Нийслэл хот байрлах энэхүү уулс хоорондын хотгорыг хүрээлэн орших уулс нь Хэнтийн нурууны баруун урд хэсгийн салбар уулс бөгөөд Монгол орны ойт хээр, хээрийн бүсийн заагт оршино.

Баянгол дүүргийн энэхүү хэсэгт үйлдвэрийн газрууд олноор төвлөрсөн газар бөгөөд антропоген, техноген нөлөөлөлд ихээр өртөж, тус үйлдвэрлэлийн бүсийн талбай

орчмын газрын гадарга, хөрс, ургамлан нөмрөг байгалийн унаган төрхөө бүрэн алдсан байна.

Уур амьсгал

Улаанбаатар хот нь Хэнтийн нурууны урд үзүүр болох Баянзүрх, Богдхан, Сонгинохайрхан, Чингэлтэй хайрхан уулсаар хүрээлэгдсэн бөгөөд Туул, Сэлбэ голуудын бэлчир хөндийд, далайн түвшнээс дээш дунджаар 1350 м өндөрт оршдог. Улаанбаатар хотын уур амьсгал нь сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай. Үнэмлэхүй бага температур нь -49°C (1954.02), үнэмлэхүй их температур нь 39.5°C (2005) хүрдэг.

Жилийн дундаж температур нь -3.0°C , хамгийн хүйтэн 1 сарын температур -26.0°C байх бөгөөд -30.0°C -аас доош хүйтрэх өдрийн тоо жилд 40 орчим байна. Цасан бүрхэвч 11 сарын 10-ны үед тогтож 3 сарын 20-д хүртэл 130 орчим хоног үргэлжилдэг бөгөөд ойролцоогоор 1.8 см зузаан цастай байна.

Хийн мандлын хур тунадас бол манай орны нутаг дэвсгэрийн уур амьсгалын нөхцлийг илэрхийлэх үндсэн үзүүлэлтийн нэг юм. Жилд орох тунадасны хэмжээ нилээд хэлбэлзэлтэй байдаг. Улаанбаатарт жилд дунджаар 238 мм тунадас унаж, ууршилт нь 648 мм болдог. Агаарын чийг дунджаар 36% байдаг. Богдхан, Чингэлтэй зэрэг ууланд хур тунадас арай их унадаг.

Агаарын чанар

Улаанбаатар хотод Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа агаарын чанарын хяналтын суурин 11 харуул (УБ 1-9, УБ-11), Нийслэлийн агаарын чанарын албаны харьяа 4 харуул (Нийслэлийн агаарын чанарын алба 1-4), агаарын чанарыг хянаж, агаар дахь түгээмэл тархалттай бохирдуулах бодис /2-6 төрөл/- ыг тодорхойлдог байна. НЬЮ СПЕЙС ХХК-ийн үйлдвэрийн барилгатай хамгийн ойр байрлах харуул нь Монгол газар ХХК-ийн орчмын харуул юм.

Харуул орчимд (1 км радиуст) гол болон туслах автозам, төмөр зам, дулааны цахилгаан станц ТЭЦ-3, барилгын материалын үйлдвэр гэх мэт тухайн орчны агаарын чанарт шууд нөлөөлөх эх үүсвэрүүд байна. Ерөнхийдөө эргэн тойрон үйлдвэр, албан байгууллага, агуулах, худалдаа үйлчилгээ ихээр төвлөрсөн бөгөөд орон сууц, гэр хороолол багатай хэсэгт байрладаг байна.

Нью Спейс ХХК-ийн үйлдвэр орчмын агаарт 2019 оны 1 дүгээр сард хийсэн хэмжилтийн үр дүнг үзэхэд 53 мкг/м^3 байгаа нь Монгол Улсын агаарын чанарын стандарт (MNS4585:2016)-д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 1.88 дахин бага, жижиг ширхэглэгт тоосонцорын агууламж 10%-иар бага байна. Энэ нь зөвхөн нэг удаагийн хэмжилтийн үр дүн бөгөөд өдрийн цагаар хэмжсэн үр дүн болно.

Гадаргын ус

Улаанбаатар хотын нутаг дэвсгэр нь Дэлхийн ус хагалбарын Хойд мөсөн далайн ай савд, Монгол орны 29 голын сав газрын Туул гол болон Хараа голын сав газарт хамаарагддаг. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт гадаргын усан сүлжээ нэлээд сайн хөгжсөн байдаг. Тухайлбал, Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт хамгийн том гадаргын усан сүлжээний илэрц нь Туул гол бөгөөд Туул гол руу цутгадаг жижиг голуудыг

дурьдвал Өвөр горхи, Дэнд, Гачуурт, Улиастай, Хөл, Сэлбэ, Толгойт, Түргэн зэрэг голууд юм.

Улаанбаатар хотын Баянгол дүүргийн нутагт орших Нью Спейс компанийн үйлдвэрийн барилга байгууламж орших нутаг дэвсгэр нь дэлхийн ус хагалбарын Хойд мөсөн далайн ай сав, Монгол орны Туул голын сав газарт багтдаг. Тус компани нь гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд багтдаггүй.

Газрын доорх ус

Тус төслийн талбай нь дэлхийн ус хагалбарын Хойт мөсөн далайн ай савд, Монгол орны Туул голын сав газарт багтах бөгөөд Улаанбаатар хот орчмын гидрогеологийн ерөнхий нөхцлийг авч үзлээ.

Улаанбаатар хотын газрын доорх ус нь уулс хоорондын артезийн ай савд багтах бөгөөд дараах 6 уст бүрдлээс бүрдэнэ. Үүнд:

- Орчин үеийн дөрөвдөгч-дээд дөрөвдөгчийн настай аллювийн хурдас дахь устай бүрдэл,
- Дээд дөрөвдөгч-Дунд дөрөвдөгчийн настай аллювийн хурдас дахь устай бүрдэл,
- Ангилалдаагүй дөрөвдөгчийн настай аллюви-пролювийн хурдас дахь устай бүрдэл,
- Неогений настай эх газрын гаралтай сэвсгэрдүү хурдас дахь устай бүрдэл,
- Цэрдийн настай эх газар-нуурын гаралтай сэвсгэрдүү хурдас дахь устай бүрдэл,
- Палеозойн настай, метаморфизсан тунамал чулуулаг дахь газрын доорх устай ан цавлаг бүс зэрэг болно.

Хөрсөн бүрхэвч

Улаанбаатар хотын нутаг дэвсгэр нь хөрс-газарзүйн мужлалаар, хөрсний өндрийн бүсшилийн субгумид хэвшинж бүхий Хэнтий орчмын 52, 43-р тойргуудад хамаарагдана. Тус талбай нь ландшафтын нөхцлөөрөө Улаанбаатар хотын бусад хэсгээс онцын ялгаагүй. Үйлдвэрийн талбай түүний орчмын геологийн тогтоцын хувьд өмнөд хэсгийг хамарч байгаа Богд уулын боржин чулуулгуудын массив дээр суурилсан голын хөндийн аллювийн, дөрөвдөгчийн аллювийн сэвсгэр хурдас болох сайтар угаагдаж мөлгөржсөн хайрга, хайрганцар, жижиг бул чулуу зонхилох ба багавтар элсэнцэр хурдас тархсан байдаг. Энэ аллювийн гарал үүсэлтэй дөрөвдөгчийн сэвсгэр хурдас нь газрын доорхи ул хөрсний агуулагч чулуулгийн бүрэлдэхүүн хэсэг болдог. Дөрөвдөгчийн сэвсгэр хурдасны зузаан нь 4-15 м, зарим хэсэгтээ 23 м орчим байна. Улаанбаатар хот орчмын хөрсийг уулын нугат-хээрийн хөрс, уулын хээрийн хөрс, чийгт гарлын хөрс, голын татмын хөрс гэж ангилсан байна. Үйлдвэрийн барилга бүхий талбай нь Улаанбаатар хотын хөрсний ангилалаар чийгт гарлын хөрс зонхилж буй хэсэгт хамаарагдаж байна. Чийгт гарлын хөрс нь байгалийн тухайн бүсийн тэгшдүү төвгөр газар оршдог ердийн хөрсийг бодвол ямагт илүү чийглэг нөхцөлд тогтворждогоороо ялгаатай.

Лабораторийн шинжилгээний үр дүнг Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008 стандарттай харьцуулж үзвэл хүнцлээс бусад элементийн агууламж стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнд байна. Харин хөрсөнд агуулагдах хүнцлийн агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн байна. Энэ нь тухайн нутаг дэвсгэр үйлдвэрлэлийн зориулалтаар он удаан

жил ашиглагдсан, нөгөө талаар тухайн хөрсний онцлог, хөрс үүсгэгч чулуулагтай холбоотой байх магадлалтай.

Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008 стандартад заасны дагуу тусгай зөвшөөрөлтэй үйлдвэрлэл, уул уурхайн бүсэд бохирдуулагч бодис, элементийн хөрсөн агуулагдах зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй адил утгаар мөрдлөгө болгоно гэсний дагуу уг үр дүнг хортой агууламжтай харьцуулж үзэхэд, уг стандартад заасан хортой агууламж (30 мг/кг)-аас хэтрээгүй байна.

Ургамлан нөмрөг

Тус талбай, түүний орчмын ургамлын төлөв байдал нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хээрийн ургамлын бүлгэмдэлд хамаарагдана. Харин Улаанбаатар хот нь ойт хээрийн бүсэд орших ба нарийвчлан үзвэл Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар Хэнтийн уулын тайгын болон Монгол Дагуурын уулын ойт хээрийн гэсэн 2 тойргийн уулзвар нутагт байрладаг.

Улаанбаатар хот, түүний орчмын хээрийн бүлгэмдэлд Крыловын хялгана (*Stipa Krylovii*), саман ерхөг (*Agropyron cristatum*), дэрвээн хазар өвс (*Cleistogenes squarrosa*), том цэцэгт дааган сүүл (*Koeleria macrantha*), сунагар биелэг өвс (*Poa attenuata*), агь (*Artemisia frigida*), ишгэн шарилж (*Artemisia dracunculus*), Адамсын шарилж (*Artemisia Adamsii*), ишгүй гичгэнэ (*Potentilla acaulis*), имт гичгэнэ (*Potentilla bifurca*), дагуур хатны цэцэг (*Symbaria dahurica*), хоёр ишт бэриш (*Bupleurum bicaule*) зонхилж оролцдог. Хужир марзтай хотгор хоолой, хөндийд дэрс зонхилсон бүлгэмдэл тохиолдоно.

Нью Спейс ХХК-ийн үйлдвэр, түүний орчмын газар нутаг нь хүний үйл ажиллагааны нөлөөгөөр талхагдалд их орсон тул хөл газрын (хүмүүнсэг) ургамал нилээд элбэг тохиолдоно. Тухайлбал, олон жил бэлчээрийг хэт ашигласнаас ургамлан бүрхэвч нь үндсэндээ сэргэх чадваргүй болтлоо талхлагдсан ба шарилж (*Artemisia*), бударгана (*Salsola*)-ын төрлийн ургамлууд эвшил үүсгэн ургадаг.

Орчны тохижуулалт, мод ургамал тарих арга хэмжээний хүрээнд үйлдвэрийн зүүн талд ойролцоогоор 50 м² талбайг зүлэгжүүлж, гацуур зэрэг мод тарьж ургуулсан байна

Амьтны аймаг

Тус компанийн үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэр нь Улаанбаатар хотод байрлах тул Нийслэлийн байгаль орчны төлөв байдал (2011)-ын судалгааны үр дүнгээс шувуу болон хөхтөн амьтдын газарзүйн мужлал болон төлөв байдлын талаар товч дурьдав.

Улаанбаатар хот орчмын газар нутаг нь Монгол орны хөхтөн амьтдын газарзүйн мужлал (Банников, 1954)–аар Хойт доод муж, тайгын провинци, Хэнтийн тойрогт багтана. Улаанбаатар хот орчмын ой, ойт хээрийн бүсэд нийтдээ 6 багт хамаарагдах 51 зүйлийн хөхтөн амьтныг судлаачид бүртгээд байсан боловч, сүүлийн үед эдгээрийн зарим зүйл нь хотжилт суурьшлын нөлөөгөөр дайжин алга болжээ. Тухайлбал, туруутнаас Халиун буга, Бор гөрөөс, Зэрлэг гахай, Баданги хүдэр, зэрэг амьтад, мах идэштнээс хүрэн баавгай, нохой зээх, ойн солонго, ойн булга зэрэг 10 гаруй зүйлийн амьтад дайжин алга болсон байна.

Харин Монгол орны шувуудын газарзүйн тархацын хуваарилалтаар Улаанбаатар, түүний орчмын нутаг нь Европ-Азийн шилмүүст ойн дэд мужийн Хэнтийн провинц ба Европ-Азийн хээрийн дэд мужийн Монгол-Дагуурын хээрийн провинцид багтах Хэнтий, Монгол Дагуурын хээрийн тойргуудад хамаарна.

Улаанбаатар хот орчмын шувуудыг тоо толгойн байдлаар авч үзвэл, элбэг буюу олон тоогоор байнга тааралддаг 7 зүйл улаанхушуут жунгаа (*Pyrrhocorax pyrrhocorax*), алагтуу хэрээ (*Corvus dauricus*), турлиах хэрээ (*Corvus frugilegus*), хар хэрээ (*Corvus corone*), хон хэрээ (*Corvus corax*), адууч чогчиго (*Oenanthe oenanthe*), хээрийн боршувуу (*Passer montanus*), ердийн буюу түгээмэл тааралддаг 21 зүйл хөхвөр тагтаа (*Columba livia*) байна.

Дуу шуугиан

Нью Спейс ХХК-ийн үйлдвэр орчимд хийсэн дуу шуугианы хэмжилтийн үр дүнг Монгол Улсын агаарын чанарын стандар MNS4585:2016-тай харьцуулахад уг стандартын 16 цагийн дунджаар тооцсон зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 1.28-1.36 дахин бага буюу стандартын шаадлагатай нийцэж байна. Харин үйлдвэр ажиллаагүй байсан учир үйлдвэр дотор хэмжилт хийгээгүй бөгөөд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад дотоод орчны дуу шуугианы түвшин өндөр байх магадлалтай. Иймд, үйлдвэрийн дотоод орчинд, дуу шуугиан ихтэй тоног төхөөрөмжийн дэргэд ажиллагсдад сонсгол хамгаалах хэрэгсэл тогтмол хэрэглүүлж хэвшүүлэх шаардлагатай юм.

Тусгай хамгаалалттай газар нутаг

Нью Спейс ХХК-ийн үйлдвэрийн үйл ажиллагаа явуулж буй байршилтай ойр орших улсын тусгай хамгаалалттай газар нутаг нь Богдхан уулын дархан цаазат газар (ДЦГ) бөгөөд энэхүү тусгай хамгаалалттай газар нутагтай давхцал байхгүй. Богдхан уулын ДЦГ нь тус байгууламжаас урд зүгт ойролцоогоор 4-5 км-ийн зайтай оршдог.

Түүх, соёлын өв

Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20 дугаар хороонд орших Нью Спейс ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж буй барилга байгууламж, түүний орчмын талбай нь Улаанбаатар хотын үйлдвэрлэлийн бүсэд оршдог. Шинээр барилга байгууламж нэмж барих, хуучин барилга байгууламжийг өргөтгөх тохиолдолд археологийн мэргэжлийн байгууллагад урьдчилан мэдэгдэх нь зүйтэй.

1.3.1 Нийгэм-эдийн засгийн өнөөгийн байдал

Хүн амын ажил эрхлэлт

Баянгол дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр тус хэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2020 оны 11 сард 1237 болж, өмнөх оны мөн үеэс 177 хүнээр (12.5%) буурсан байна. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 624 нь (50.4%) эмэгтэйчүүд байна.

Насны бүлгээр авч үзвэл бүртгэлтэй нийт бүртгэлтэй ажилгүй иргэний 187 нь (15.1%) 15-24 насны, 424 нь (34.3%) 25-34 насны, 354 нь (28.6%) 35-44 насны, 212 нь (17.1%) 45-54 насны, 50 нь (4.0%) 55-59 насны, 10 нь (0.8%) 60-аас дээш насны хүмүүс байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 25 нь (3.3%) хөгжлийн бэрхшээлтэй иргэд бөгөөд үүнээс 12 нь (48.0%) эмэгтэйчүүд байна. Баянгол дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн хөдөлмөр эрхлэлтийн албанд 2020 оны 11 сард 474 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 96 иргэн ажилд зуучлагдан орж, 261 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.

Дүүргийн төсөв

Төсвийн орлого 2020 оны 11 сарын байдлаар 95 244.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 7 339.1 сая төгрөгөөр (7.2%)-аар бага бүрдсэн байна. Төсвийн нийт орлогын 25.1 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 74.9 хувийг татварын бус орлого тус тус эзэлж байна. Татварын орлогын дүнд хувь хүний орлогын албан татварын шилжүүлэг хамгийн өндөр буюу 20 828.1 сая төгрөгийг (87.1%) эзэлж байна.

Төсвийн нийт зарлага 2020 оны 11 сард 92 095.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 17 118.3 сая төгрөгөөр (15.7%) буурсан байна. Төсвийн нийт зарлагын дүнд урсгал зардал хамгийн өндөр буюу 94.2 хувийг эзэлж байна.

Хэрэглээний үнэ

2020 оны 11 дүгээр сарын хэрэглээний үнийн индекс 2019 оны эцэстэй харьцуулахад 3.7 хувь, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.3 хувь, өмнөх сартай харьцуулахад 0.7 хувиар тус тус өссөн байна.

Хэрэглээний үнийн индекс 2020 оны 11 дүгээр сард өмнөх оны эцэстэй харьцуулахад 3.7 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 8.1 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн үнэ 5.0 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 3.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 5.6 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 2.4 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 3.0 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний үнэ 0.1 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ 0.7 хувиар, боловсролын үйлчилгээ бүлгийн үнэ 0.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 5.7 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 4.3 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

2020 оны 11 дүгээр сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 344 нэрийн бараа, үйлчилгээний 22.1 хувийнх нь үнэ өсөж, 2.6 хувийнх нь үнэ буурч, 75.3 хувийн бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байв.

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын мэдээнд хамрагддаг аж ахуйн нэгжүүд 2020 оны эхний 11 сард 418.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бөгөөд нийт үйлдвэрлэлийн 19.6 хувийг уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбар, 79.3 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар, 1.1 хувийг усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа эзэлж байна. Нийт үйлдвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 78.3 тэрбум төгрөг (23.1%)-өөр өссөн байна.

Оны эхний 11 сарын байдлаар нийт 530.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.3 хувиар өссөн байна.

1.4 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Ноос, ноолуур угаах үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгэм-эдийн засагт нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолтыг дараах байдлаар тусгав.

1.4.1 Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Ноос угаах шингэн саван, угаалгын нунтаг, бохир ус цэвэрлэх бодисуудыг тээвэрлэж явах үед тээврийн хэрэгслийн осол гарч болзошгүй бөгөөд үүний улмаас угаалгын бодис, бохир ус цэвэрлэх бодис тухайн орчинд асгарч, хэсэг газрын гадарга бохирдож болзошгүй.

Төсөл хэрэгжих хугацаанд ашиглаж буй тээврийн хэрэгслүүдийн эвдрэл, ажилчдын санамсар болгоомжгүй үйл ажиллагаанаас шатах тослох материал асгаран газрын гадаргыг бохирдуулж болзошгүй.

1.4.2 Уур амьсгалд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Ноос, ноолуур, угаалгын бодис тээвэрлэлтийн явцад тээврийн хэрэгслүүдээс CO₂ ба NO₂ хийнүүд, ялгарч тэр хэмжээгээр хүлэмжийн хийн ялгарал нэмэгдэхэд нөлөөлнө.

1.4.3 Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Гадаад орчны агаар

Ноос угаах үйлдвэр нь төвийн халаалалтад холбогдсон учир үйлдвэр орчмын агаарын чанарт агаар бохирдуулагч түгээмэл хий ялгаруулахгүй. Харин түүхий эд, угаалгын бодис, угаасан ноос, ноолуур тээвэрлэх үед тээврийн хэрэгслээс агаар бохирдуулагч хийнүүд ялгарах бөгөөд агаарын чанарт нөлөөлөх нөлөөлөл нь бага бөгөөд богино хугацаанд үргэлжлэх юм. Дулааны улиралд ноос, ноолуур угаах үйлдвэр, түүхий эдийн агуулахаас малын зунгаг, шивхний үнэр бага зэрэг гарч болзошгүй.

Дотоод орчны агаар

Болзошгүй сөрөг нөлөөлөл

- Үйлдвэр болон агуулахын агааржуулалтын хэвийн ажиллагаа алдагдсанаас ажлын байрны агаарын чанар муудах, ажилчдын эрүүл мэнд сөргөөр нөлөөлөх,
- Химийн бодисыг хадгалах үед агуулахад химийн бодис ууршиж, дотоод агаарын бохирдол үүсэх.

1.4.4 Гадаргын усанд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Үйлдвэрийн ноос, ноолуур угаах үйл ажиллагаанд усыг эргүүлэн ашиглаж байгаа ба үйлдвэр дэх бохир ус цэвэрлэх байгууламжаар дамжуулан төвлөрсөн бохирын шугамд нийлүүлэх төв цэвэрлэх байгууламжид нийлүүлдэг тул гадаргын усанд шууд нөлөөлөхгүй.

1.4.5 Газрын доорх усанд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Тус төсөлд технологийн зориулалтаар төвлөрсөн шугам болон гүний худгаас ус авч ашигладаг ба үйлдвэрт шинээр суурилуулсан цэвэрлэх байгууламжид ноос, ноолуур угаасан усыг цэвэршүүлж, усны дахин ашиглалтыг нэмэгдүүлэн ажиллана. Хэдий тийм боловч доорх болзошгүй нөлөөллийг үзүүлж болзошгүй. Үүнд:

- Үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа доголдох, технологийн горим зөрчигдсөний улмаас дутуу цэвэрлэсэн ус төв цэвэрлэх байгууламж руу нийлүүлж, ачааллыг нэмж болзошгүй,
- Үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа доголдсоны улмаас эргүүлэн ашиглах усны хэмжээ багасч, сэлбэлтийн усны хэрэглээ нэмэгдэж болзошгүй.
- Үйлдвэрийн бохир усны цэвэрлэх байгууламж, бохир ус зайлуулах шугам бөглөрсөнөөс бохир ус хальж, газрын гадарга хэвлий, улмаар газрын доорх усыг бохирдуулж болзошгүй.
- Мөн ноос угаах үйлдвэрт ашиглагдаж буй машин техникээс ШТМ газрын гадаргад алдагдсан тохиолдолд хур тунадасны усаар угаагдан, хөрсөөр дамжин гадаргын болон газрын доорх усыг бохирдуулж болзошгүй.
- Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрээс гарч буй бохир усанд шүлтийн нэгдлүүдийн агууламж өндөр байдаг. Дараах нөхцөлөөс шалтгаалж газрын доорх усны нөөцийг бохирдуулж болзошгүй.
 - Үйлдвэрийн технологийн бохир усыг зохих норм, шаардлагын дагуу хэмжээнд хүртэл цэвэрлээгүй;
 - Химийн бодисыг үйлдвэрлэгчийн зөвлөсөн хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэсэн;
 - Ажиллагсдын хайнга байдал эсвэл дутуу дулимаг мэргэшсэн, дадлагажсан байдал.

1.4.6 Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас доорх болзошгүй нөлөөллийг хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй. Үүнд:

- Үйлдвэрийн машин техникийн засвар үйлчилгээний явцад сольсон сэлбэг, хэрэгсэл, тостой даавуу, хаягдал тосолгооны материалыг хяналтгүй хаясан тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй бөгөөд улмаар гадаргын болон газрын доорх усыг бохирдуулж болзошгүй.
- Бохир ус цэвэрлэх байгууламжийн лаг болон үнэрийн бохирдлын хавсарсан үйлчлэлээр орчны хөрсөн дэх бактерийн хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс давж, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.

1.4.7 Ургамлан нөмрөгт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Тус үйлдвэрийг 2007 онд байгуулах явцад ургамлан нөмрөг нөлөөлөлд өртсөн ба шинээр үүсэх нөлөөлөл байхгүй.

1.4.8 Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Тус үйлдвэрийг 2007 онд байгуулсан ба амьтны аймагт шинээр үүсэх нөлөөлөл байхгүй.

1.4.9 Дуу шуугианаас нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Тус үйлдвэр нь үйлдвэрлэлийн бүсэд орших бөгөөд үйлдвэрийн үйл ажиллагаанаас суурьшлын бүсэд үзүүлэх шууд нөлөөлөл байхгүй.

1.4.10 Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас тусгай хамгаалалттай газар нутагт шууд нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй.

1.4.11 Түүх, соёлын өвд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас түүх, соёлын өвд шууд нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй.

1.4.12 Нийгэм эдийн засагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

- Тус үйлдвэр нь Баянгол дүүргийн үйлдвэрийн тойрогт орших бөгөөд ойр орчимд нь үйлдвэрийн газрууд байрлах тул ноос, ноолуур угаах үйлдвэрийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэрийн иргэд, суурьшлын бүсэд шууд үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй.

1.5 Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго нь Баянгол дүүргийн нутагт байрлах Нью Спейс ХХК-ийн ноос, ноолуур угаах үйлдвэрийн төсөл хэрэгжиж буй талбай, түүний ойр орчмын нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, нөхөн сэргээх, төлөвлөж буй төслийн талбай, түүний орчимд үүсэж болзошгүй байгаль орчны сөрөг нөлөөллийг хянаж, илрүүлэхэд оршино.

Төслийн 2023 оны “Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г 2020 онд батлагдсан БОННУ, БОМТ (5 жил)-нд үндэслэн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” болон тус журмын хавсралтуудыг баримтлан боловсруулав.

Хүснэгт 1-1 Ноос, ноолуур угаах үйлдвэрийн төслийн 2023 оны БОМТ-ний нийт зардлын хураангуй

#	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3,225,000
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	570,000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	300,000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2,085,000
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн	200,000

#	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал, төг
	төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	350,000
Нийт зардал, төг		6,530,000

1.6 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Ноос, ноолуур угаах үйлдвэрийн төслийн үйл ажиллагааны явцад хэрэгжүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан доорх хүснэгтэд нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 1-2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал	Тайлбар	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
Газрын гадарга, хэвлий, хөрсөн бүрхэвч									
<p><u>Болзошгүй сөрөг нөлөөлөл</u></p> <p>Ноос угаах шингэн саван, угаалгын нунтаг, бохир ус цэвэрлэх бодисуудыг тээвэрлэж явах үед тээврийн хэрэгслийн осол гарч болзошгүй бөгөөд үүний улмаас угаалгын бодис, бохир ус цэвэрлэх бодис тухайн орчинд асгарч, хэсэг газрын гадарга бохирдож болзошгүй.</p>	<p>- Тээврийн хэрэгслийн хурдыг замын хөдөлгөөний дүрэмд заасны дагуу тохируулж, замын тэмдэг, тэмдэглээг сайтар анхаарах, дагаж мөрдөж явах</p>	Тээвэрлэлт	төгрөг	-	-	Цалингийн санд тусгах (ХАБЭА хариуцсан ажилтан)	ХАБЭА хариуцсан ажилтны цалингийн санд тусгах. Туслан гүйцэтгэгчийн гэрээнд тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	2023	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
	<p>Тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж, эвдрэлийг цаг тухайд нь илрүүлж засварлаж ажиллах</p>	Тээвэрлэлт	Төгрөг	-	-	Цалингийн санд тусгах (ХАБЭА хариуцсан ажилтан)	ХАБЭА хариуцсан ажилтны цалингийн санд тусгах. Туслан гүйцэтгэгчийн тээврийн хэрэгслийг тээвэрлэлтэд явахаас өмнө бүрэн бүтэн байдлыг шалгасан хуудсыг хянаж, архивлах		Замын хөдөлгөөний дүрэм
	<p>- Хальтиргаа гулгаатай үед зохих бэлтгэлийг хангаж, болгоомжтой хөдөлгөөнд оролцох, онц их хальтиргаа гулгаатай бол тээвэрлэлтийг нөхцөл байдлыг арилтал хойшлуулах</p>	Тээвэрлэлт	төгрөг	-	-	Цалингийн санд тусгах (ХАБЭА хариуцсан ажилтан)	ХАБЭА хариуцсан ажилтны цалингийн санд тусгах. Туслан гүйцэтгэгчийн гэрээнд тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах		Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
<p>Төсөл хэрэгжих хугацаанд ашиглаж буй тээврийн хэрэгслүүдийн</p>	<p>Автомашиныг тээвэрлэлтэд гаргахын өмнө техникийн бүрэн бүтэн байдал,</p>	Тээвэрлэлт	төгрөг	-	-	Цалингийн санд тусгах (ХАБЭА хариуцсан ажилтан)	ХАБЭА хариуцсан ажилтны цалингийн санд тусгах. Туслан гүйцэтгэгчийн	2023	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
									Хөрс

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал	Тайлбар	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
